

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/31

Арвайхээр сум

┌ Улирлын томуугийн эсрэг вакцинаар ┐
дархлаажуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн “Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/334 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2025 оны 09 дүгээр сарын 15-наас 25-ны өдрүүдэд “Томуугийн халдвараас сэргийлье” уриан дор зохион байгуулсугай.

2. Улирлын томуугийн эсрэг “GCFLU”, “SKYCellflu” дөрвөн цэнт вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг нэгдүгээр, улирлын томуугийн эсрэг вакцинаар зорилтот бүлгийг дархлаажуулахад анхаарах зөвлөмжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Улирлын томуугийн эсрэг вакцинаар жирэмсэн эмэгтэйчүүд, эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтан, хүүхдийн байгууллагын багш, ажилчид, 65 ба түүнээс дээш насныхан болон архаг хууч өвчтэй хүмүүс, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 6 сартайгаас 6 хүртэлх насны хүүхдийг дархлаажуулах ажлыг зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын 10 хоногоор заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолоос хоцорсон 15 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулах, дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтийн хэвлэл мэдээллээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг даалгасугай.

5. Вакцин, дагалдах хэрэгслийг хүлээн авч, эргэлтийн хөрөнгөөр бүртгэн, зарцуулалтад нь хяналт тавьж, санхүүгийн тайланд тусгахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНБАЯР

622501111
My Doc.tushaal/EMG

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 15- ний
өдрийн 13.4 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

Улирлын томуугийн эсрэг "GCFLU", "SKYCellflu" дөрвөн цэнт вакцин,
дагалдах хэрэгслийн хуваарь

Д/д	Сум, өрхийн нэр	Вакцинд хамруулах зорилтот бүлэг								Шаардлагатай вакцин, тариур	
		"ЖиСи Флю" (GCFLU) вакцин (10 хүн тун)				"Скай селлфлю" (SKY Cellflu) вакцин (1 хүн тун)					
		6 сартайгаас 6 хүртэлх насны хүүхэд	Жирэмсэн эмэгтэй	Хүүхдийн байгууллагын багш, ажилчид	Нийт	ЭМБ-ын ажилтан	65 болон түүнээс дээш насны хүн ам	Архаг хууч өвчтэй хүн	Нийт	Олгох хүн тун	Тариур 0.5 мл
1	Баруунбаян-Улаан	100			100	21	40	40	101	201	100
2	Бат-Өлзий	325	5		330	37	101	45	183	513	330
3	Баянгол	140			140	24	59	32	115	255	140
4	Баян-Өндөр	140			140	25	81	17	123	263	140
5	Богд	275	5		280	28	64	33	125	405	280
6	Бүрд	110			110	17	55	17	89	199	110
7	Гучин-Ус	80			80	18	40	24	82	162	80
8	Есөнзүйл	100			100	23	62	20	105	205	100
9	Зүүнбаян-Улаан	130			130	21	69	43	133	263	130
10	Нарийнтээл	130			130	30	57	22	109	239	130
11	Өлзийт	80			80	21	58	26	105	185	80
12	Сант	140			140	20	67	32	119	259	140
13	Тарагт	140			140	19	59	32	110	250	140
14	Төгрөг	100			100	21	42	40	103	203	100
15	Уянга	445	5		450	42	122	100	264	714	450
16	Хайрхандулаан	140			140	21	60	72	153	293	140
17	Хархорин	550	10		560	116	317	68	501	1061	560

18	Хужирт	265	5			270	34	155	84	273	543	270
19	Нарныдеш	910	20		40	970	27	242	175	444	1414	970
20	Уянсэтгэл	515	10		35	560	23	200	133	356	916	560
21	Түшигдөлгөөн	495	10		35	540	23	240	125	388	928	540
22	БӨЭТ						332			332	332	
23	ЭМГ						37			37	37	
24	ЗӨСТ						20			20	20	
	Нийт	5310	70	110		5490	1000	2190	1180	4370	9860	5490

оОо

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 15.....
өдрийн 4/31 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт

Улирлын томуугийн эсрэг вакцинаар зорилтот бүлгийг
дархлаажуулахад анхаарах зөвлөмж

Улирлын томуугийн эсрэг Бүгд Найрамдах Солонгос улсын 4 цэнт “GCFLU”, “SKYCellflu” вакцинаар 6 сартайгаас 6 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтан, хүүхдийн байгууллагын багш, ажилчид, 65 ба түүнээс дээш насны хүмүүс, архаг хууч өвчтэй хүмүүсийг дархлаажуулах ажлыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/334 дүгээр тушаалын 2-5 дугаар хавсралтын дагуу 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс “Томуугийн халдвараас сэргийлье” уриан дор аймгийн хэмжээнд зохион байгуулна.

2024/2025 оны томуугийн улиралд хийсэн томуугийн дархлаажуулалтын бүртгэл, төлөвлөлт, хамралт, эрсдэлийн харилцаанд дэмжлэгт хяналтыг 32 нэгжид хийхэд томуугийн вакцинд хамруулах зорилтот бүлгийг төлөвлөх, судалгааг шинэчлэх шаардлагатай, мэдээлэл цахим биш, цаасан бүртгэл байгаа боловч хангалтгүй зарим тоон мэдээлэл зөрөх зэрэг алдаа дутагдал байсан. Мөн 2 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн вакцины хамралт бага байсан. Энэ нь гэрээр хүмүүждэг хүүхдийн судалгаанд үндэслэн дархлаажуулалтыг хийдэггүй, мэдээллийг хүртээмжтэй хүргэдэггүй, хамралтын байдалд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулдаггүй зэрэг голлох шалтгаануудтай холбоотой байсан.

Иймд 2025-2026 оны томуугийн дархлаажуулалтын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Улирлын томуугийн эсрэг “GCFLU” вакцинаар 6 сартайгаас 6 хүртэлх насны хүүхэд (эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн), жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхдийн байгууллагын багш нарыг дархлаажуулах
2. Улирлын томуугийн эсрэг “SKYCellflu” вакцинаар эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтан, 65 болон түүнээс дээш насны хүн ам болон архаг хууч өвчтэй хүмүүсийг дархлаажуулах
3. Вакцинд хамрагдах зорилтот бүлгийн хүн амыг дараах байдлаар эрэмбэлж, нэн тэргүүнд вакцинд хамруулах бүлгийг тодорхойлох. Үүнд:
 - 3.1. 6 сартайгаас 2 хүртэлх насны хүүхэд
 - 3.1.1. Өмнөх томуугийн улиралд амьсгалын замын халдварт өртөх давтамж өндөр байсан;
 - 3.1.2. Архаг, суурь өвчтэй;

- 3.1.3. Томуугийн халдвараар хүндрэх эрсдэлтэй;
- 3.1.4. Эмнэлгийн тусламж авахад бэрхшээлтэй
- 3.1.5. Эрүүл мэндийн байгууллагаас алслагдсан газар оршин суудаг
- 3.2. Архан хууч өвчтэй хүмүүс. Үүнд:
 - 3.2.1. Уушигны архаг өвчин (астма, архаг гуурсан хоолойн үрэвсэл, уушигны фиброз, гуурсан хоолойн тэлэлт)
 - 3.2.2. Зүрх судасны өвчин (Зүрхний дутагдал, зүрхний ишеми, тархины харвалт өгч байсан өгүүлэмжтэй)
 - 3.2.3. Чихрийн шижин, бодисын солилцооны эмгэг
 - 3.2.4. Бөөрний архаг дутагдал
 - 3.2.5. Дархлаа дарангуйлагдсан байдал (хавдар, ХДХВ-ийн халдвартай, эрхтэн шилжүүлсэн г.м)
 - 3.2.6. Элэгний архаг эмгэг
 - 3.2.7. Мэдрэлийн архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- 4. Вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгийг чанартай хийж, цахим бүртгэлд оруулах
- 5. Томуугийн вакцинд хамрагдсан иргэний мэдээллийг дархлаажуулалтын цахим бүртгэлийн системд шивж, бүртгэлжүүлэх, зорилтот бүлгийн хүн амын хамралтын мэдээг насны бүлэг, ажил мэргэжлийн ангиллаар ЭМС-ын тушаалд заасны дагуу өдөр бүрийн 10:00 цагаас өмнө гарган нэгтгэж, ЭМГ-ын НЭМХ-т мэдээлэх, анхан шатны нэгж дээрх бүртгэлийг сайжруулах, цахим хэлбэрт оруулах
- 6. Дархлаажуулалтыг зохион байгуулахдаа хүүхдийн байгууллагыг түшиглэн зохион байгуулж болох хэдий ч гэрээр хүмүүжиж байгаа хүүхдийг орхигдуулахгүй байх
- 7. Вакцин хийсний дараа дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалтыг хийж, хариу арга хэмжээг шуурхай авах
- 8. Эмч, мэргэжилтнүүд томуугийн вакцины үр нөлөө, ач холбогдлын талаар зорилтод бүлгийн хүн ам, ялангуяа бага насны хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, жирэмсэн эмэгтэйчүүдэд тайлбарлан сурталчлах
- 9. Томуугийн вакцины талаар иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, хороо, баг, хэсгийн ахлагч нартай хамтран зорилтот бүлэгт мэдээлэл хүргэх, иргэдийн хүсэлтэд нийцсэн мэдээллээр хангах